



I-III/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 14



Нийтийн хоолны салбарын орлого өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буурчээ


Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны эхний улиралд 114.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.7 (5.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх улирлаас 16.2 тэрбум төгрөг буюу 16.4 хувиар өссөн байна. Өмнөх мөн үеэс буурахад захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлого 5.8 (20.3%) тэрбум төгрөг, гуанзных 0.8 (11.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Нийтийн хоолны салбарын орлого, зардал, жил бүрийн эхний улирлын байдлаар, зоогийн газрын төрлөөр, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021* I-III	2021*I-III 2020 I-III
Нийт орлого	85.5	105.6	121.3	114.6	94.4
Ресторан	45.1	61.2	76.3	76.4	100.1
Кафе	7.4	7.9	7.4	7.2	97.1
Баар	3.5	4.2	2.5	2.4	96.8
Гуанз	5.8	7.2	6.5	5.7	88.4
Захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ	23.6	25.1	28.6	22.8	79.7
Нийт зарлага	74.5	100.9	104.2	104.7	100.5
Ресторан	41.1	60.7	72.3	70.6	97.6
Кафе	5.5	7.6	7.1	6.5	92.1
Баар	3.1	4.1	2.4	2.2	93.5
Гуанз	4.3	7.0	6.0	5.2	87.7
Захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ	20.5	21.5	16.5	20.2	122.2

Нийтийн хоолны газрын орлогод рестораны орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.8 пункт, кафены орлогынх 0.2 пункт, баарны орлогынх 0.1 пунктээр өсөж, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогынх 3.7 пункт гуанзны орлогынх 0.3 пунктээр түс түс буурсан байна.

Зураг 1. Нийтийн хоолны салбарын орлого, жил бүрийн эхний улирлын байдлаар, зоогийн газрын төрлөөр, тэрбум төгрөг



Зочид буудлын салбарын орлого 2021 оны эхний улиралд 33.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 (3.8%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх улирлаас 3.6 (12.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Өмнөх оны мөн үеэс 3, түүнээс дээш одтой буудлын орлого 2.3 (9.0%) тэрбум төгрөгөөр буурч, зэрэглэлгүй зочид буудлын орлого 1.1 (13.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Зочид буудлын салбарын орлого, зардал, жил бүрийн эхний улирлын байдлаар, зочид буудлын зэрэглэлээр

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021*I-I-III	$\frac{2021^*I-III}{2020 I-III}$ %
Нийт орлого	27.7	61.8	35.2	33.8	96.2
Зэрэглэлгүй буудал	6.5	12.1	8.4	9.6	113.3
2 одтой буудал	0.9	1.4	0.6	0.5	81.4
3, түүнээс дээш одтой буудал	20.4	48.3	26.1	23.7	91.0
Нийт зардал	43.6	77.1	58.6	47.9	81.7
Зэрэглэлгүй буудал	6.8	12.2	8.6	5.5	63.7
2 одтой буудал	1.0	1.5	0.7	0.5	74.7
3, түүнээс дээш одтой буудал	35.8	63.5	49.3	41.9	85.0

Зочид буудлын салбарын орлогод 3 ба түүнээс дээш одтой буудлын орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.0 пункт, 2 одтой зочид буудлын орлогынх 0.3 пунктээр тус тус буурч, зэрэглэлгүй зочид буудлын орлогынх 4.3 пунктээр өссөн байна.

Зураг 2. Зочид буудлын салбарын орлого, буудлын зэрэглэлээр, улирлаар, тэрбум төгрөг



Хүлээж авсан зочид 2021 оны эхний улиралд 35.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 22.1 (38.1%) мянгаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.

Тооцох аргачлал:

Нийт орлого: Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны үйлчилгээний орлогын нийлбэр байна. Нийт зардал: Зочид бүүдал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон гарсан болон үйл ажиллагааны бусад төрлийн зардал (ажиллагчдын үндсэн ба нэмэгдэл цалин, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, тээврийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл зэрэг) - ыг оруулна.

Өрөөний тоо: Тухайн үйлчилгээний газрын байшин, барилгын зочдыг хоноход зориулсан өрөө, тасалгааны тоо юм.

Суудлын тоо: Захиалгат хоол хүргэлтийн үйлчилгээнээс бусад зоогийн газруудын суудлын тооны нийлбэрээр тооцно.

Эх үүсвэр: ҮСХ, Зочид бүүдал, нийтийн хоолны салбарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангилал.

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 16

*Эдийн засгийн статистикийн газрын
ахлах шинжээч Ч.Мөнхтуул
Утас : (976-51)-261565*

*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-263152*

